

МОНГОЛЫН ДҮРСЛЭХ УРЛАГТ ДУТАГДАЖ БУЙ ШҮҮМЖ СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДЛЫГ ХӨНДӨХ НЬ

Төмөр-Очирын Сэлэнгэ

Доктор (Ph.D), Монгол улсын багшийн их сургуулийн Дүрслэх урлаг технологийн сургууль Дүрслэх урлагийн тэнхим, Улаанбаатар, Монгол улс
selenge@msue.edu.mn

Хураангуй: Урлаг зөвхөн танин мэдэхүйн ач холбогдолтой бус түүтээр дамжуулан гоо сайхны таашаалыг төлөвшүүлэх, улмаар хүний мэдрэхүй, оюун санааг хөгжүүлэх, авьяас билгийг нээх, бүтээл туурвих урам зоригийг бадраадаг билээ. Харин дүрслэх урлагийн тухай нийтлэг болон өвөрмөц зүй тогтлыг нийгмийн хөгжлийн түүхтэй хамт уялдуулан шинжлэгч урлаг судлал нь бүтээл туурвилын эх сурвалж, уран сайхны сэтгэлгээний онцлог, нийгэмд гүйцэтгэх үүрэг, бүтээсэн арга барил зэргийг зураач урчуудын намтар түүхтэй нь авч үздэгээрээ цогц мэдлэг олгодог. Тиймээс дэлхийн бүхий л оронд мэргэжлийн мэргэшсэн урлаг судлаачдын орон зай нэн арвин ба урлагийн бүтээлүүдийн шүүмж, анализууд үнэ цэнтэйгээр хөгждөг билээ.

Монголын дүрслэх урлаг цаг үеийнхээ нөхцөл байдалд нийцэхийн зэрэгцээ урлагийн хөгжлийн жам ёсоор “даравч дардайна” гэдгээр хадны сүт зураг дүрслэлээс үүдээд контемпорари буюу орчин үеийн урлаг болтлоо хөгжсөөр ирсэн баялаг түүхтэй. Бидний мэдэх соц-реализмын үед нам засгийн үзэл суртлын бодлогоос шууд хамаарч, хязгаарлагдмал байсан хэдий ч уран бүтээлчийн чөлөөт сэтгэлгээг хязгаарлах боломж байгаагүйг түүх бүтээгчдийн бүтээл бэлхнээ харуулдаг. Тэр үед өнөөгийн нийгмийн дүр зургийг бодоход урлаг судлалыг Дашбалдан агсан тэргүүлэн тодорхой төвшинд хөгжүүлж байсан. XXI зууны эхэн үеийн монголын дүрслэх урлаг судлал хөгжлийнхөө зогсонги байдалд орсон гэхэд буруудахгүй. Учир нь урлаг судлалын өгүүлэл илтгэл багагүй бүтээгдсэн боловч нэг талыг барьсан судалгаанууд олширсон байна.

Шүүмж судлалыг зөвхөн урлаг судлалын хүрээнд бус шинжлэх ухааны үүднээс дэлгэрүүлэн судлах шаардлагатай хэмээн үзэж, дараах байдлаар дэлгэрүүлжээ. Үүнд: шүүмжийн талаарх эрдэмтдийн тодорхойлолт, судалгаа шинжилгээний ажлыг авч үзлээ. Шүүмж судлалын онол практикийн ач холбогдлыг тодорхой хэмжээнд таниулахыг зорьсон ба жишээ болгон уран зургийн шүүмжийг интерпретацийн аргаар задлан авч үзэв.

Тулхуур үгс: урлагийн онол, урлаг судлал, шүүмж судлал, уран зураг, анализ



REVIEW OF MONGOLIA FINE ARTS INVESTIGATION OF SOME RESEARCH PROBLEMS

Selenge Tumor-Ochir

Doctor (Ph.D), Department of Fine Art, School of Fine Art and Technology, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia
selenge@msue.edu.mn

Abstract: Art is not only cognitively important, but through it, it cultivates aesthetic pleasure, develops human senses and mind, and opens talents. Visual arts studies provide comprehensive knowledge by considering the sources of creativity, features of artistic thinking, role in society, and methods of creation, along with the biographies of artists. Therefore, in all countries of the world, there is a lot of space for professional art historians, and reviews and analyzes of works of art develop with value.

Mongolian visual art has a rich history that has evolved from petroglyphs to contemporary or modern art. In the era of social-realism as we know it, although it was limited directly by the ideological policy of the party government, there was no opportunity to limit the free thinking of the artist, the works of the history makers clearly show. At that time, considering the current social scene, art studies were developed at a certain level under the leadership of Dashbaldan researcher. It would not be wrong to say that Mongolian visual arts studies at the beginning of the 21st century have stagnated in their development. Because art studies articles have been created a lot, but one-sided studies have increased. Criticism needs to be studied not only in the field of art studies, but also from a scientific point of view. In this, the definitions of scientists and research work on criticism are considered. The importance of the theory and practice of critical studies was aimed to be known to a certain extent, and as an example, the criticism of paintings was analyzed by the interpretation method.

Keywords: *art theory, art studies, criticism, painting, analysis*

Оршил

Урлаг судлалын ач холбогдол: Урлаг судлал түүхэн явцдаа 3 үндсэн хүрээг хөгжүүлж, урлагийн дотоод мөн чанарыг тайлбарлах болсон.

1. Урлагийн түүх
2. Урлагийн онол
3. Урлагийн шүүмжлэл юм.

Урлагийн түүх гэдэг бол урлагийн баримтуудыг системчилж байгаа тогтолцоо юм. Иймээс урлагийн түүхийн хувьд цаг хугацааны бодит зүй тогтлыг тогтоож, түүнээс урган гарах чиг үзүүрийг барьж ажиллах шаардлагатай болдог. Түүхээр судлагдаж байгаа эрин үе нь онцгой содон биш ч үзэгдэл нэр үйлдэл бүхэн өөрийн ахуйн, энгийн баримт, мөн чанарын хүчийг агуулж байгаа гэдгийг мэдэх хэрэгтэй. Зарим урлагийн түүхчид орчин үеийн урлагийг дээд оргил мэт үздэг боловч судлаачийн гол үүрэг нь цаг хугацааг нэвтрэн хөдөлгөгч үзэл санаа, тэмүүллийг нээн харуулахад чиглэнэ (Ариунаа, 2017).

Урлагийн онол гэдэг бол түүхэн болон философийн үзэл баримтлалын үүднээс бүрэлдэж хуримтлагдсан урлагийн тухай мэдлэгийг нэгтгэж урлаг судлалын рефлекс болгоныг хэлнэ. Энэ нь логик бүтэц тогтолцоогоор илэрхийлэгдэх бол уран сайхны онолын үзэл баримтлал нь тус тусдаа ялгагдаж, сэтгэлгээний бүтэц зохион байгуулалтад нэгтгэгдсэнийг хэлнэ.

Урлагийн бүтээл нь цэцэн ухаан, уран төсөөлөл, гоо сайхны ойлголтын цогц бөгөөд бүх цаг үеийн туршид төрөл зүйл онолын хувьд ялгагдаж ирсэн байдаг. Оросын судлаач Каген.М.С урлагийн онол ба түүхийн ялгааг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Урлагийн бүтээл бүр цор ганц бөгөөд зөвхөн өөрийнхөө шинж чанараар судлагдах ёстой. Иймд цорын ганц бүтээлээс нөгөө бүтээл рүү шилжих нь урлагийн түүх болно.
2. Урлагийн бүтээл бүр тодорхой төрөл зүйл ангилалд хамаарах ерөнхий шинжтэй, үүнийг урлагийн онол судална. /Мөн чанарыг урлагийн онол судална./

Судалгааны арга зүй

Шүүмж судлалын онол практикийн ач холбогдлыг тодорхой хэмжээнд таниулахыг зорьсон ба жишээ болгон уран зургийн шүүмжийг интерпретацийн аргаар задлан авч үзэв.

Үндсэн судалгаа

Урлаг шүүмжлэл гэдэг бол урлаг судлалын бүтцэд байгаа рефлекс бөгөөд онцгой байр суурьтай. Шүүмжлэл нь уран сайхны амьдралын салшгүй бодис /юмс/ юм. Уран бүтээлч хүн тухайн цаг үедээ түүхэн уран сайхны ойлголт төрлүүдийн хүрээнд бүтээлээ туурвиж байгаа. Харин шүүмжлэл бол урлагийн бүтээлийн тогтолцоонд оршин тогтнох үндэслэл ба зарчим болдог онцлогтой (Paul Smith, 2002).

Шүүмжлэл нь урлагийн ямар ч эхлэлд зайлшгүй байх эргэцүүлэл бөгөөд уран сайхны соёлын олон талт үзэгдэл үйл явцын дунд үйлдвэрлэл, хэрэгцээ, хадгалалт зэрэг ойлголт хамт бүрэлдэж байдаг ойлголт юм. Шүүмжлэлгүйгээр урлагийн ертөнцөд ямар ч хөгжил хөдөлгөөн өрнөхгүй. Шүүмжлэл нь тодорхой зарчимтай ялангуяа урлагийн бүтээлийн тогтолцоо дунд ерөнхий шинж төлөв байдлыг тодорхойлон оршдог. XVIII зуун хүртэлх урлагийн бүтээл нь ихэвчлэн өөрийн рефлексийн шинж чанартай хөгжсөн. Гэхдээ олон судлаачдын хувьд уран сайхны шүүмжлэл гэдэг ойлголтыг хэдийд зохион байгуулалттай хэлбэр болж ядсан гэдэгт хариулт өгч чадахгүй байна.

Нэг үгээр хэлбэл, шүүмжлэл нь үүргийн хувьд янз бүрээр тайлбарлагдаж байсан. Гэвч урлагийн бүтээлийн шүүмжлэл ба үр дүнгийн тухай нэгэн зүйл дээр тогтож чадсан байдаг. Энэ нь шүүмжлэл өөрөө урлагийн бүтээлийн тогтолцооны зохион байгуулалтын зарчмыг тодорхойлоход чиглэнэ гэсэн ойлголт юм.

Гэхдээ уран сайхны шүүмжлэл гэдэг бол жирийн үзэгдэл биш. Түүнийг олон янзын эх сурвалжаар тайлбарлах ёстой. Хамгийн түгээмэл байдлаар 3 янзын контекстийг уран сайхны шүүмжлэлийн хувьд анализ, үзэгдлийн хүрээнд тодорхойлж болно. Үүнд:

1. Соёлын үйлдвэрлэлийн, ерөнхий талбараас эх сурвалжаа авах

2. Орчин үеийн урлагийн тогтолцооны явцуу хүрээнээс эх сурвалжаа авах
3. Уран сайхны шүүмжлэлийн өөрийнх нь талбараас шүүмжилж болно.

Урлаг нь дээр өгүүлсэн агуулгуудын хүрээнд уран сайхны соёлын систем болж тогтсон. Нөгөө талаас, урлагийн өнөөгийн нөхцөл байдал нь өөртөө зохион байгуулалттай, учир шалтгаантай өмнөх тогтолцооны шинж чанараас хамааралтай үзэгдэл болж хөгжиж байна. Иймд урлагийн шүүмжлэлийг өөрийнх нь талбарын хүрээнд судлахдаа шүүмжлэлт сэтгэлгээний хувьсал сэтгэлгээнээс нь авдаг /уламжлалт, шинэчлэл/. Харин орчин үед шүүмжлэлийг туршаагүйгээр сэтгэшгүй гэж тодорхойлж байгаа нь антекийн илтгэх урлаг, философийн урлагийн онолыг дурдаж буй хэрэг юм. Урлагийн шүүмжлэл нь соёлын рефлекс бөгөөд өөрөө хөгжигч тогтолцоо гэдгийг анхаарах хэрэгтэй. Шүүмжлэл гэдэг бол түүхэн цаг үед өөрийн онцлог болон зайлшгүй нөхцөлөөр бүрэлдэж, нийгмийн харилцааны үнэт чанарыг зохицуулагч үзэгдэл болж чадах ойлголт юм. Энэхүү зохицуулагч нь 2 үүрэгтэй:

1. Шууд үүрэгтэй - нийгмээс урлаг руу чиглэсэн.
2. Эргэх үүрэг - урлагаас нийгэм лүү чиглэсэн үүрэг.

Уран сайхны шүүмжлэл нь уран сайхны соёл ба уран сайхны бус соёлд харилцааг зохицуулах ба харилцааг зохицуулах бус үүрэг гүйцэтгэдэг.

Уран сайхны шүүмжлэл нь хамгийн хөдөлгөөнт хэсэг бөгөөд урлаг судлалын үндсэн асуудлуудыг тайлбарласан урлаг судлалын хүрээнээс гарах боломж нь болдог.

Уран сайхны шүүмжлэл нь урлаг судлалын бүтцэд чухал үүрэгтэй учир соёлын танин мэдэхүй, үйл ажиллагаа бүтэц онцлогт нягт холбогддог. Соёл ба урлагийн таньж ялгахад зайлшгүй мэдэх 3 төрлийн рефлекс байдаг.

1. Урлаг соёлын мэдлэг, үйлдлийг шүүмжлэн, тэдгээрийн хил хязгаар, ач холбогдлыг эргэцүүлэн дүгнэх рефлекс
2. Онолын мэдлэгийн анализ ба шүүмжлэлийг шинжлэх ухааны судалгааны салбарт ашиглах аргыг боловсронгуй болгох
3. Соёлыг ахуй ба сэтгэлгээний тодорхой нөхцөл ухамсраар тайлбарлах рефлекс

Урлагийн түүх, онол, шүүмжлэлийг дээр дурдсан 3 рефлекс хүрээнд авч үздэг. Урлагийн түүх нь урлагийн тухай мэдлэгийг ангилж, түүхэн дэс дарааллаар авч үздэг ба бүтээлийн агуулгын ач холбогдол, урлагийн хөгжлийн цаг үе, үе шатных нь хил хязгаарыг тогтоож байдаг. Урлагийн түүхийн хувьд бүтээл гэдэг нь түүхэн үйл явцын үр дүн, тодорхой дэг, зохиогчийн үйл ажиллагааны илрэл, уран сайхны материаллаг нөхцөл байдлыг орон зай, цаг хугацааны ертөнцийг үзэх үзлийн үр дүн гэж ойлгогдоно. Харин урлагийн онол нь урьдчилсан нөхцөлүүдийг дамжиж, шүүмжлэлүүдийн хүчээр урлагийн ойлголт хуулиуд, урлагийн бүтээлийн шинж чанар, уран сайхны үйл явцын илэрхийлэл мөн чанарыг тодорхойлж судалж байдаг.

Урлаг зөвхөн танин мэдэхүйн ач холбогдолтой бус түүгээр дамжуулан гоо сайхны таашаалыг төлөвшүүлэх, улмаар хүний мэдрэхүй, оюун санааг хөгжүүлэх, авьяас билгийг нээх, бүтээл туурвих урам зоригийг бадраадаг билээ. Харин дүрслэх урлагийн тухай нийтлэг болон өвөрмөц зүй тогтлыг нийгмийн хөгжлийн түүхтэй хамт уялдуулан шинжлэгч урлаг судлал нь бүтээл туурвилын эх сурвалж, уран

сайхны сэтгэлгээний онцлог, нийгэмд гүйцэтгэх үүрэг, бүтээсэн арга барил зэргийг зураач урчуудын намтар түүхтэй нь авч үздэгээрээ цогц мэдлэг олгодог. Тиймээс дэлхийн бүхий л оронд мэргэжлийн мэргэшсэн урлаг судлаачдын орон зай нэн арвин ба урлагийн бүтээлүүдийн шүүмж, анализууд үнэ цэнтэйгээр хөгждөг билээ.

Судалгааны ажлын талаарх эрдэмтдийн тодорхойлсноор: “Шийдэл шаардсан тодорхой асуудлын мөн чанарыг тодорхойлох дэс дараатай, зохион байгуулалттай хүчин чармайлтыг судалгаа гэнэ” гэж эрдэмтэн Б.Жадамба (2001) тодорхойлсон бол “Тодорхой асуудалд хариулах эсвэл баримтад тулгуурлан түүнийг шийдвэрлэх зохион байгуулалттай, дэс дараатай, бүтээлч танин мэдэх үйл ажиллагааг судалгаа гэнэ” хэмээн судлаач Ц.Чимэдлхам (2001) ном зохиолдоо тусгасан байна. Харин эрдэмтэн Ш.Ичинхорлоо (2009) “судалгааны ажил гэдэг бол сургуулийн амьдралд гарч буй аливаа асуудлыг зорилго чиглэлтэй судалж шийдвэрлэх бүтээлч үйл ажиллагаа” гэж тодорхойлсон нь боловсрол судлалын судалгааны ажлыг тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд, шинжлэх ухааны салбар бүрийн судалгаа шинжилгээ нь өөрийн гэсэн онцлогийг агуулдаг бөгөөд жишээ нь; боловсрол судлалын судалгааны ажлыг дүрслэх урлагтай жишин харьцуулна гэхэд тун бэрхшээлтэй нь ойлгомжтой юм. Гэвч шинжлэх ухааны салбар бүрийн судалгааны ажилд нийтлэг шинж байдаг. Үүнд: Судалгааг хоёр ангилан үздэг.

1. Суурь судалгаа – Шинэ мэдлэг, үзэл баримжаа, онол, хууль зүй тогтлыг тодруулах зорилгоор хийж буй судалгааг суурь судалгаа гэнэ. Мэдлэг бүтээх үйл ажиллагаа нь суурь судалгаа болно. Бүтээсэн мэдлэгийн ачаар шинэ суурь онол, үзэл баримжаа бий болдог. Суурь судалгааг ихэвчлэн Шинжлэх ухааны академиуд, Их сургуулиуд, Коллежид хийдэг. Учир нь суурь судалгааны зорилго нь тулгамдсан асуудлыг шийдэж, танин мэдэхүйн цар хүрээг тэлэх зорилготой юм. Иймээс судалгааны үр дүнг шууд амьдралд нэвтрүүлэх зорилгыг агуулдаггүй бөгөөд энэ нь нээх, тайлбарлах, танилцуулах чиглэлтэй байдаг боловч ихэнх тохиолдолд шинэ зүй тогтлыг нээхэд анхаардаг.

2. Хавсарга судалгаа – Амьдрал, үйлдвэрлэлээр дэвшсэн асуудлын үр дүнг нь үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор судалж байгаа бол хавсарга судалгаа гэнэ. Хэрэгцээг үнэлэх, үр ашигт шинжилгээ, үнэлгээ хийх нь хавсарга судалгаанд чухал ач холбогдол нь бөгөөд практик ач холбогдолтой судалгаа хийх нь уг судалгааны гол зорилго юм.

Дээрхээс үзэхэд, дүрслэх урлаг судлалын судалгааны ажлууд нь суурь судалгаанд хамрагдаж байна. Тухайлбал, дүрслэх урлагийн судалгааны ажлын зорилго нь:

1. ДУ-ын салбарын мэдлэгийн хүрээг өргөтгөн шинэчлэх
2. ДУ-ын хөгжлийн чиг хандлагатай уялдан дэвшсэн асуудлыг шийдэх
3. Шинэлэг санааг дэвшүүлэх
4. Шинэ мэдлэг бүтээх
5. Онолын үндэслэл дээр харьцуулалт хийх зэрэг ерөнхий агуулгыг багтаасан байна.

Шүүмж судалгааны талаарх эрдэмтдийн тодорхойлсноор “Шүүмж бол мэргэжлийн ном, сэтгүүлийн эх материал, өгүүлэлд буй мэдээллийг задлан шинжлэх, өмнө олж авсан мэдээлэлтэй жиших, үнэлж дүгнэх зэрэг үйлдлийг

бичгээр болон ярих байдлаар хийхийг хэлнэ” гэж доктор Ш.Ичинхорлоо (2009) тодорхойлсон бол урлагийн талаас нь Д.Дашбалдан (1988) судлаач “Шүүмж бол урлагт оршиж байгаа үнэнийг өгүүлэхийг хэлнэ” хэмээн тодорхойлсонтой санал нэг байна. Сүүлийн жилүүдэд урлаг судлалын ном зохиол, сэтгүүл, өгүүллэгүүд их хөгжиж байгаа боловч ихэнх бүтээлүүд онолд тулгуурлах бус танин мэдэхүйн хүрээнд бичигдсэн байна. Тухайлбал; Бүтээлийг хэт нэг талаас сайшаан бичих, уянгын халил романтик санаа нэмэх, дөвийлгөн өөрийн санааг шууд тусгах зэрэг орох боловч ихэнх судлаачид өнгөн талаас нь бичих нь ихэсжээ. Гэвч монголын урлаг судлалд шүүмж судалгаа огт байгаагүй гэвэл өрөөсгөл ойлголт болно. Судлаач Д.Дашбалдан 1975 онд нээгдсэн залуу зураачдын уран бүтээлийн үзэсгэлэнгийн талаар “Урлах эрдэм, уран чадвараа дээшлүүлье” шүүмж бичиж уншигчдын хүртээл болгож байсан. Мөн “Утга зохиол, урлаг” сонин, “Дүрслэх урлаг” сэтгүүлийн 1977, 1980 хэвлүүлсэн тухайн үеийн шүүмжлэлт өгүүллэгээрээ шагнал авч байсан байна.

Уран зургийн хөгжил, түүхчилсэн байдлаар бичигдсэн бүтээл бүрийг нэг талын үзүүрээр харж бичиж байгаа нь нөгөө талыг хөгжүүлэхэд асар том саад бэрхшээл болж байна. Учир нь аливаа оршин тогтнож буй эд эс бүхэн сайн муу талыг агуулдаг гэж бодвол урлагийн бүтээлд ч энэ нь харилцан адилгүй тусна. Сайн бүтээл байхын сацуу саар бүтээл ч олон бий. Тэгвэл монголын дүрслэх урлагийн ертөнцөд шүүмжийн асуудал дутмаг буйг дараах байдлаар тодотгоё.

Монголын дүрслэх урлагийн ном зохиолд интерпертаци хийх гэж оролдов / Уран зургийн тухай ном зохиолын жишээн дээр/. Интерпертацийг – номын агуулга, арга зүй, ач холбогдол, дэвшүүлсэн буй асуудал, номын хэрэгцээ шаардлага, шүүмжийн асуудлыг аль талаас нь хөндсөн зэргээр нягтлан үзсэн болно.

Дүрслэх урлагийн судлагдсан байдлыг товч дурдвал:

1960-аад оноос дүрслэх урлагийн хөгжил хурдтай өрнөж, Монгол болон Зөвлөлт Холбоот Улсын судлаач эрдэмтдийн судалгаа шинжилгээний ажлууд багагүй хийгдсэн байна. Ялангуяа 1970-аад оноос “Дүрслэх урлаг” сэтгүүл хэвлэгдэж эхэлсэн нь монголын дүрслэх урлаг судлалд томоохон хувь нэмэр болжээ.

Улмаар 1975 онд судалгааны ажил эрхэлдэг бие даасан эрдэм шинжилгээний байгууллагатай болж, монголын дүрслэх урлагийн товч түүхийг хамт олны хүчээр боловсруулж эхэлсэн байдаг. Тухайн үед зөвхөн монгол эрдэмтэд бус гадаадын монголч эрдэмтэн судлаач нар манай дүрслэх урлагийг судалж байсны дотор оросын монголч эрдэмтэд ихээхэн байр суурийг эзэлдэг. Н.Н.Бельский, К.В.Вьякина, С.В.Кесилев зэрэг судлаачид монголын дүрслэх урлагийн хувьсгалын эхэн үеийн уран зургийн судалгаа хийж үлдээжээ. Мөн судлаач сэтгүүлч И.И.Ломакина “Социалист Монголын дүрслэх урлаг” бүтээлдээ ХХ зууны монголын дүрслэх урлагийн төлөвийг судалсан ба О.И.Галерина монголын дүрслэх урлагийг тойм байдлаар нэгтгэн судалж үзсэн байна. А.Гончаров “Зохиомжийн тухай” Дүрслэх урлаг сэтгүүл №48 /т.24-27/-д хэвлүүлсэн тус өгүүлэл нь зохиомжийн тэнцвэрт байдал, онолыг практикт хэрхэн тулгуурлан дүрслэх зэрэг олон талт асуудлыг шийдвэрлэж өгсөн нь тухайн үеийн суралцагчид болон залуу боловсон хүчнүүдэд нэн хэрэгцээт нийтлэл байжээ.

1980-аад оноос Л.Сономцэрэн, С.Лувсанвандан, Л.Батчулуун, Д.Дашбалдан, Т.Галбадрах, Б.Бадрах, Д.Майдар нараас монголын дүрслэх урлагийн түүхэн тойм, уламжлал шинэчлэлийн асуудал, төрөл зүйл, ардын урлагийн талаар хийсэн судалгаа, нийтлүүлсэн бүтээлүүд нь дүрслэх урлагийн хөгжлийн хувьслыг судлахад тулгуур болж байна. Мөн дээр дурдсан эрдэмтдийн шинэ цагийн дүрслэх урлагийн талаарх ном зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байдлаас тухайн үед шинэ содон байсан модерн уран зургийн онолын ойлголтыг өгөх зорилго агуулсан эрдэм шинжилгээний болон танин мэдэхүйн зорилготой бүтээлүүд гарч байжээ. Л.Сономцэрэнгийн “Монголын шинэ цагийн дүрслэх урлаг” (1968) бүтээлд хувьсгалын ардчилсан шатны дүрслэх урлагийн түүхэн хөгжлийг судалж нэгтгэн дүгнэхийг зорьсон ба 1921-1940 оны реалист уран зургийг МАХН-ын бодлоготой уялдуулж, магтан сайшаасан зохиол бичсэн байна.

Д.Дашбалдан судлаачийн “Уран зураг орчин үе” ном нь шинэ урлагийг зураачийн ур чадвартай хослуулан бичсэн байгаагаараа онцлог байна. Н.Цүлтэм, Л.Сономцэрэн нарын “Монголын уран зургийн хөгжиж ирсэн товч түүх”(1986) бүтээлд 1920-1980 оны шинэ цагийн дүрслэх урлагийн хөгжлийн төлөвийг нэгтгэн бичихийг зорьсон бөгөөд ардын эрхт монголын уран сайхны соёл, түүний нэгэн төрөл зүйл, дүрслэх урлаг социалист реализмын гоо зүйн зарчим дээр төлөвшиж хөгжсөн замналыг шинжлэн дүгнэсэн байна. Мөн Н.Цүлтэм “Шинэ Монголын дүрслэх урлаг” өгүүлэл бичиж түүндээ дүрслэх урлагийн төрөл зүйлийг үүсгэлцэхэд ахмад уран бүтээлчдийн оруулсан хувь нэмрийг тодруулахыг эрмэлзсэн байна.

Урлаг судлаач Л.Батчулуун “Эсгийн урлаг, тэмдгийн тогтолцоо”(2003) судалгааны бүтээлдээ хэзэ угалзны өнгө, дүрс, хэлбэрийг үүсгэгч анхдагч элемент зураас, цэг тэмдгийн тогтолцоо бөгөөд уран сайхны сэтгэлгээний аль ч хэлбэр гарвацийн унаган төрхийг хадгалж, хөгждөг зүй тогтолтой байсны нарийвчлан судалжээ. Харин судлаач Б.Бадрах судалгаа бүтээлдээ Монголын зураасан зургийн үүсэл хөгжлийг авч үзэхдээ уламжлал шинэчлэлийн уялдаа холбоон дээр тодорхойлон нарийвчилж, судалгааны суурийг тавьж өгсөн байна. Академич Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн нар монголын дүрслэх урлагийн төрөл зүйл нэрт зураач, тэдгээрийн уран бүтээлийн талаарх эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэлүүд нийтлүүлсэн нь ихээхэн ач холбогдолтой болжээ. Харин дээр дурдсан бүтээлүүдэд судлаачид модерн уран зургийг тойм төдий бүтээлдээ оруулсан байна.

Эртний хадны зураг дүрслэл нь түүх, аж байдлын домог зүй, гүн ухааны тусгал юм. Эрдэмтэн С.Батчулуун “Монголын уламжлалт уран зураг дүрслэл дэх уран сайхны илэрхийллийн онцлогийг судалсан нь” бүтээлээ эртний монголчуудын хийсвэрлэх сэтгэлгээг хадны сүг зургийн жишээн дээр тодотгон бичсэн байна. Мөн судлаач С.Дулам “Монгол бэлгэдэл зүй” хэмээх цуврал бүтээлүүддээ өнгө, дүрслэл, зүг чигийн утга бэлгэдлийг нарийвчлан судалсан байна. Уг бүтээлүүд нь ардын урлаг болон өнөө үеийн урлаг судлалд бэлгэдлийн талаасаа үнэтэй хувь нэмрийг оруулсаар байгаа билээ. Нэн ялангуяа “Зүүд, зөн совингийн бэлгэдэл зүй” (2002), “Өнгийн бэлгэдэл зүй” гэх зэрэг бүтээлийг нь дурдаж болно.

XX зууны эхний хагас бүхэлдээ социалист реализмын үзэл суртлын хязгаарлагдмал сэтгэлгээний хүрээнд багтаж байлаа. Харин ардчилсан үзэл баримтлал хөгжиж эхэлснээр дүрслэх урлаг, түүний судлал, шүүмжлэлд хийсвэрлэх

урлаг, модернист урлагийн төрлүүд түгжигдмэл байдлаасаа тэсрэн газар авч, дүрслэх урлагийн онол, түүх, дадлагын аль ч талаар шинэчлэнгүй аяс дэлгэрч, судалгааны бүтээлүүд гарч нийтийн бүтээлүүд болсоор байгаа билээ.

Өөрөөр хэлбэл, 1990 оноос монголын дүрслэх урлагийн талаарх ном зохиол, бүтээл туурвил ихээр туурвигдах болсон юм. Ялангуяа тухайн үед эрчимтэй хөгжиж байсан модерн урлагийн талаарх нарийвчлан, гүнзгийрүүлэн, задлан шинжилсэн бүтээлүүд гарч эхэлсэн байна. Доктор Б.Баяртөр (2014) “XX зууны дунд үеэс өрнөдийн уран зургийн барилд уламжлалт зургийн аргыг хослуульж, уламжлалыг хадгалсан шинэ маяг хөгжсөн болохыг, урлаг судлаач Ц.Эрдэнэцог эрт эдүгээ цагийн тодорхой туурвилд тулгуурлан судалж бичсэн байна” хэмээн судалгааны ажлыг нь дүгнэсэн байна.

Урлаг судлаач Ц.Уранчимэг “XX зууны өрнөдийн урлаг” номдоо модерн уран зургийн үүсэл гарвалыг нягтлан судалсан нь шинэ урлагийн цаашдын судалгаанд томоохон байр суурийг эзлэхээр бүтээл болсон юм. Учир нь уг бүтээл нь Өрнөдийн модерн урлагийн хөгжиж ирсэн түүхэн гарвал, модерн урлагт багтдаг томоохон “измүүд”-ийг тайлбарлан бичсэн байна. Гэвч өнгө, зохиомж, арга ажиллагааны талаар нарийвчлан судлаагүй ба танин мэдэхүйн ном зохиол болсон байна. Гэхдээ модерн урлагийг нарийвчлан судалсан багагүй бүтээлүүд байна. Жишээлбэл, уран зураг судлахын хамгийн чухал хэсэг нь өнгө, зохицол билээ. Судлаач Ц.Эрдэнэцог (2006) судалгааны бүтээлүүддээ модерн уран зургийн өнгө, зохицлын онцлогийг нарийвчлан задалж судалсан байна.

Судалгааны үр дүн

Монголын уран зургийн тойм, арга ажиллагаа, түүхэн хөгжлийг гүнзгийрүүлэн судалсан бүтээлүүд цөөнгүй боловч дийлэнх нь уламжилж ирсэн түүхэн замнал, хөгжил, зураачийг намтарчилж, тэдгээрийн бүтээлүүдийг хүүрнэн өгүүлэх байдлаар дурдан бичсэн зэрэг нь судалгааны явцад ажиглагдлаа. Дээрх дурдсан бичгийн илэрхийлэл нь урлаг судлалын нэгэн өгөгдөл боловч дотоод мөн чанар, үзэл баримтлал, арга зүйг гүнзгий судлах шаардлагатай юм. Дэлгэрүүлэн авч үзвэл /уран зургийн жишээн дээр/:

1. Уран зургийн зохиомж дүрслэлийг уран зураг дахь хоосон орон зай дүрсийн хэмнэл буюу ритм, дүрүүдийн үүрэг, түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдээр нь задлан бичих
2. Уран зургийн өнгө - уран зураг дахь өнгийн хоршил, нийцэл, хүний сэтгэл зүйд хэрхэн тусах, өнгийн алслалтыг бүрэн тодотгох, хүйтэн дулааныг дүрүүдийн байршил дээрээс унших
3. Уран зургийн арга ажиллагаа - тосон будаг, усан будаг шороон будаг гэх мэт зурагдсан хэрэглэгдэхүүнийг анхлан харах боловч уусгалт, манаргалт, фактурлаг зэрэг олон янзын ажиллагааг судлах шаардлага урган гарна. Мөн хэрэглэгдэхүүн бүрийг нарийвчлан авч үзэх ба ерөнхий хэллэгт тулгуурлаж дүгнэлт хийхийг мартаж болохгүй.
4. Эцэст нь тухайн зурсан зураачийн дотоод сэтгэлгээний илэрхийлэл буюу ертөнцийг үзэх үзэл, бодрол, илэрхийлэх гэж буй санаа, мэдрэмж нэн чухал юм.

Уран зургийн анализ буюу уран зургийн уншихад гол хүчин зүйл нь дээрх боловч дүрслэх урлагийн бүтээл бүрд харилцан адилгүй тусна. Мэдээж уран барилга, баримлыг дээрхийн адил дөрөвхөн зүйлээр тайлбарлана гэвэл дутмаг мэдлэг болох нь тодорхой.

Монголын уран зургийн хөгжил нь нийгмийн эрэлт хэрэгцээний дагуу сэдэв агуулгаар баяжигдсаар ирлээ. Тиймдээ ч бидний мэдэх уран зураг өнөөдөр далд утгатай, агуулгаар баялаг, тэр бүр илэрхийлээд байдаггүй сэдвүүдтэй, хязгаарлагдмал бус нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэхүйц болж задарч чадсан нь уран зургийн хөгжил хурдацтай байгаагийн илрэл юм. Мөн уран зургийн нийгэмд үзүүлэх нөлөө асар их тул нийгмийг ил далд хэлбэрээр шүүмжилсэн бүтээлүүд мөн зэрэгцэн хөгжиж байгаа бөгөөд тэдний зурах арга барил бүр өөр хоорондоо ялгаатай байна. Тиймд уран зургийн анализыг онолын түвшинд судалж уран зургийг нарийвчлан тайлбар шаардлага тулгарна.

Дараах байдлаар ангилал хийх санал оруулъя /Орчин үеийн уран зургийн жишээн дээр авч үзэв/:

Дүрийг тодотгосон анализ /шүүмж/-ыг До.Болд “Одод тэнгэр орчиж” бүтээлд тусгав.



Зураг 1. До.Болд “Одод тэнгэр орчиж” зургийн хэсгээс

До.Болд “Одод тэнгэр орчиж” бүтээл нь сэтгэлгээний хэв шинжит урлаг ба далд утга агуулга, ёгт этгээд дүрсүүдийн тоглолтоор баяжигдсан бүтээл юм. Бүтээлийн дотоод илэрхийлэл нь дайн байлдаан, амьдралын зөрчил тэмцлийг харуулсан байна. Зурагт нум сумаа онилон байлдах дайчин эрсийг морьт цэргүүд давхилдан эргэх мэт. Залуу бүсгүйн харцыг цагаан морины өөдөөс аврал эрсэн мэт ширтүүлсэн нь айдас, жихүүдэс агуулсан гунигт дүрийг тодотгожээ. Уян налархай биеэрээ тэнцэл, тулааныг зөөлрүүлэн

байгаа залуу бүсгүйг хөнгөн цайвар өнгөөр зохиомжийн төвд зурсан нь хүний нүдэнд шууд тусна. Зургийн зүүн дээд буланд монгол эрийн шийдэмгий харц, дайчин төрхийг дөвийлгөн харуулахыг эрмэлзсэн байна. Энэхүү дайчин эрийн сумны өнгө нь хөндлөн дүрсэлсэн илдийн талстад шингэж, эгц урагш шулуун татан зурсан өнгийн хурц тоглолтоос харагдана. Зургийн баруун дээд буланд тулалдаанаас зугтан дайчих шаргал морийг дүрсэлсэн байх ба цэрэг эр морин дээрээ үхэтхийн унах мэт тонгойсон байрлалтай зуржээ. Зураач энэхүү зургийг “Одод тэнгэр орчиж” хэмээн нэр өгсөн нь дээрх дүрүүдийн тоглолт, утгын мөн чанарт уялдуулахыг зорьсон боловч дайны үймээн самуун, түүнийг гай уршиг, ололт амжилтыг бүхнийг одод түгсэн тэнгэртэй зүйрлэж ийнхүү өгсөн байна.

Арга ажиллагааг тодотгосон анализ /шүүмж/-ийг Ч.Болдбаатар “Гэгээн дурсамж” бүтээлд тусгав.



Зураг 2. Ч.Болдбаатар “Гэгээн дурсамж”

Хүн, нийгмийн хөгжил хурдацтай хөгжихийн хирээр урлаг, соёлын хүрээ түүнийгээ даган хувьсан өөрчлөгдөг. Тиймдээ ч уран зургийн өнгө, арга ажиллагаа, сэдэв агуулга нь шинэчлэгдсээр чөлөөт сэтгэлгээнд хүрчээ. Зураач бүрийн сэтгэхүйн цар хүрээг өндөр түвшинд шаарддаг урлагийн нэг нь абстракт урсгал юм. Абстракт уран зургийн нэршлийг хийсвэр гэж шууд утгаар нь орчуулах нь учир дутагдалтай. Учир нь бодит бус хэллэг дотор дис зохиомж, де зохиомж гэх мэт зохиомжийн шийдлүүд, дотоод сэтгэлийн хөдлөл, мэдрэмж, агууламж, үзэгдэл, хязгааргүй сэтгэлгээ хүртэл агуулагддаг байна.

XX зууны төгсгөл үеэс монголын модерн уран зургийн өнгийн тодорхойлж эхэлсэн зураач бол Ч.Болдбаатар юм. Тэрээр модерн уран зургийн онол, практикийг хослуулан бүтээлээ туурвидаг байснаар онцлогтой. Бүтээл бүр нь далд онжид утга, өнгө, зохиомжийн шинэлэг шийдэл, фактурлаг бичилттэй байдгаас гадна илэрхийлж буй санаа бүр нь дахин давтагдашгүй байдаг. Тухайлбал; “Гэгээн дурсамж” бүтээлийг онцлов. Абстракт урлагт өнгийн бэлгэдэл, өнгө хүний сэтгэл зүйд хэр тусдаг зэрэг шинжлэх ухааны ололтууд чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, өнгийг ажиллахад гарах гол үр дагавар нь сэтгэл зүйн нөлөөлөл юм. “Гэгээн дурсамж” хэмээх нэршил ариун гэгээлэг бүхий л зүйлийн бэлгэдэл болсон цагаан өнгөтэй шууд хоршин байна. Цул цагаан фон дээр хэдхэн бичилт, дүрс өгснөөр утга санаа улам төгөлдөржсөн байна. Хэсэгчлэн авч үзвэл:

Арга ажиллагаа - Фактурлаг бичилт, бийрийн эрчимт татал зэргээр зургийг хослуулан ажиллажээ. Цул цагаан фон дээр эрчимлэг хүчтэй татсан бичилт нь орон зайн шийдлийг тэнцвэржүүлж, зохиомжийн шийдэлд нөлөөлж чаджээ.

Гэгээн дурсамжийн гол дүр нь хоёр хундага, түүнийг тойрсон хэдэн бичилт юм. Сааралдуу өнгийн гадаргууд хүч түрэн харагдах цав цагаан хэсэгт байрлуулсан хундаганы дүрсээр уулзалт, болзоо зэргийн илэрхийлсэн мэт. Бийрийн таталт, бичилт бүр нь агшин зуурын эмоцийн хөдөлгөөн ба өнгийн хоршил, нэгдлээр утгыг гаргажээ.

Зураг бүхэн зураачийн амьдралын нэгээхэн хэсэг байдгийн адил уг зурагт уран бүтээлчийн залуу насны гэгээлэг нэгэн дурсамжийн тольдсон гэж ойлгож болно.

Урлагийн сэтгэл судлалыг тодотгосон анализ /шүүмж/-ийг До.Болд “Шаргачин тахиа жилийн шинийн 17” бүтээлд тусгав. XX зууны урлагт гарсан дүрслэн илэрхийлэх олон арван арга барилын нэг нь абстракт урлаг юм.

Абстракт урлаг дахь хийсвэр сэтгэлгээний дүр дүрслэлийн хослолыг 1910-аад оны үед Кандинский, Пийт Мондриан нар үндэслэжээ. Манай Монголд абстракт урлаг 1960-аад оноос хөгжсөн байна.



Зураг 3. До.Болд “Шаргачин тахиа жилийн шинийн 17”

Абстракт уран зургийн өнгө бүр хүний сэтгэхүйд өөр өөрөөр тусдаг тул хүний мэдрэмжид хүчтэй нөлөөлдөг зохиомжгүй /хийсвэр/ зохиомж, өнгийн тоглолтоор шууд ойлгогддоогоороо бусад урсгалаас онцлогтой. До.Болд зураачийн “Шаргачин тахиа жилийн шинийн 17” хэмээх бүтээл нь монголын уран зургийн хөгжилд хурц, тод бичилт мэт хүчтэй орж ирсэн гэж хэлж болно. Зургийн зохиомжийн дүрслэл бүр нарийн төвөгтэй хөдөлгөөнтэй ба хөдөлгөөн бүрд нь танин мэдэхүйн нэгэн өвөрмөц зам байдаг. Дэндүү гэгээлэг өнгө

тоноор зурагдсан энэхүү зургийн онцлог нь хурц өнгөнүүдээр бүрэн илэрхийлэгдэж байгаа боловч тоглолт бүрийн өнгийн шилжилт, дагнаас, уусалт гэх мэт нарийн хэллэг нь зургийг тодотгосон гэж болно. Энэхүү зургийг бүрэн мэдэрье гэвэл хүний сэтгэлгээнд өнгө хэрхэн тусдагийг нарийвчлан судлах шаардлага урган гардаг. Тухайлбал; шар өнгө - гэрэл гэгээг санагдуулдаг боловч алтан нарны бэлгэдэл гэж үздэг. Улаан өнгө - тэмцлийн өнгө гэх ба цог золбоог илэрхийлдэг. Ногоон өнгө - амар тайвны илэрхийлдэг болдог бол цагаан өнгө - энх тайван, эхийн цагаан сүүний илэрхийлэл мэт ариухан, цэвэр тунгалаг гэх мэт илэрхийллүүдээр тусдаг.

Үүнээс үзэхэд “Шаргачин тахиа жилийн шинийн 17” бүтээл нь зураачид хүчтэй мэдрэмж төрүүлсэн өдөр гэж үзэж болох ба гэгээлэг, сайхан дурсамж, сэтгэл зүйг авчирсан байгаа нь зураг дахь өнгийн сонголтоос харагдаж байна. Зургийг нь сайтар ажиглавал морины дүрслэл харагдана. Тэрхүү морины толгой хэсгийг нарийвчлан судалбал, бийрийн цацлага, бичилт нь дэндүү нягт агаад хар бараан толбо дээр цагаан толбо шигтгэж, нүд хэсгийг дүрсэлжээ. Үүнээс үзэхэд, До.Болд зураачийн бүтээл нь зохиомж, дүрслэл, арга ажиллагаагаараа тэр нэгэн өдрийн дэндүү жаргалтай дурсамжийг өгүүлэхийг эрмэлзсэн мэт.

Хэтрүүлэгт, хийсвэр санааг тодотгосон анализ /шүүмж/-ийг Л.Бавуудорж “Эх” бүтээлд тусгав.

Хүн ба ертөнцийн үзэгдэл, байгалийн юмсын өнгө, дүрсийн зохиролдох сайхныг мэдэрч, тэдгээрийг дүрсэлж илэрхийлэх урлахуйн сэтгэлгээ бүрэлдэн тогтсон нь оюуны хөгжилд гарсан том дэвшил юм. Тэрхүү дэвшилд бодит болон бодит бус олон урсгал, сэдэв жанраар хөгжсөн ба тэр бүрд уянгын халил тодорхой хэмжээгээр үргэлж тусдаг. Зурагт гүн утга агуулга, далд онжид дүрслэл, хэний ч тааварлашгүй зохиомж гэх мэт нь шинийг эрэлхийлэх санаа бүр чухал ач холбогдолтой боловч хүний сэтгэлийн утсыг хөндөх нь нэн чухал. Харааны яруу найраг гэгддэг зураг бүр сэтгэлийн утсыг хөндөх хэдий ч уянгын халил илүүтэйгээр зүрхэнд тусдаг.





Зураг 5. Л.Бавуудорж “Эх” зургийн хэсгээс

XX зууны монголын уран зургийн хөгжлийн өнгө төрхөд реалист арга ажиллагаагаар зурсан эмгэний дүр хүч түрэн орж ирсэн билээ. Захиа барин нулимс нь мэлтэлзэх түүний нүднээс гуниг тээн, аврал эрэх мэт харах нь үзэгчдэд нэгийг бодогдуулах аж. Судлаачид гол дүрийг цэргээс ирэх хүүтээ хүлээн буй хэмээн бичдэг ба зарим нь хүү нь насан эцэс болсныг мэдсэн эмгэнэлт дүр хэмээн тодотгосон байна. Харин өчүүхэн миний өнцгөөс харахад гол дүрийн эмгэний дүрийг ойлгох, нууцыг тайлах зангилаа нь хойно буй цагаан ботго юм. Цагаан ботго эмгэн лүү гунигтайхан ширтсэн нь түүний хүлээсэн хүнийг харуулсан мэт. Гэвч ботгыг гадаснаас уяснаар очих хүслэн байвч хясах золыг илтгэж чаджээ. Үүнээс үзэхэд, эмгэн, ботго хоёулаа гол дүр бөгөөд энэхүү эмгэнэлт үзэгдлийг арын фон, өнгөөр улам баяжуулжээ. Тухайлбал, уйтгар гунигийг хав харанхуй тэнгэрээр төлөөлүүлэн, зэгэл шаргал газрыг уусган холбосон зэрэг нь утга санаанд хүч болон чимэгджээ.

Дүгнэлт

Дүрслэх урлаг судлалд сэдэвт зохиол, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл, сонин сэтгүүлийн нийтлэл зэрэг тоймгүй их эрдэм шинжилгээний бичвэр олны хүртээл болгосон байна. Тиймдээ ч тус тэнхимээс шинжлэх ухааны доктор, профессор, доктор, доцент, урлаг судлалын ухааны магистр, урлаг судлалын бакалаврууд төрөн гарсан байна. Судалгааг тоймлон багцалбал:

- Уламжлалт зан заншил, сэтгэлгээний хэв шинжит бүтээлүүд дэх судалгаа
- Социалист монголын дүрслэх урлагийн түүхэн туршлага, ололт амжилтын талаарх судалгаа
- Намтарчилсан судлал
- Монголын зураг дүрслэлийн уран сайхны илэрхийллийг задлан шинжилсэн судалгаа
- Уран бүтээлийн түүхэн судалгаа
- Уран бүтээлийн анализ, зохиомж дүрслэл, өнгө, арга ажиллагааны судалгаа
- Танин мэдэхүйн судалгаа
- Харьцуулсан судалгаа
- Орчин үеийн зураг дүрслэл /модерн, контемпорари/
- Зан үйл, ёс заншил, угсаатны зүйн судалгаа зэрэг олон агуулгын хувьд бичигджээ.

Дээрх судалгаа шинжилгээний бүтээл бүр:

- Нийгмийн харилцааг улам боловсронгуй болгох, өнөө үеийн шинэ хүнийг хүмүүжүүлэх, хүмүүсийн гоо зүйн ёс суртахууны хүмүүжлийг дээшлүүлэх зорилготой.